

ТАНИЛЦУУЛГА

2016 оны 07 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн
дүнгийн талаар

Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2016 оны эхний 6 сард иргэд, байгууллагаас 4897 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8 нэгж буюу 0.2 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 166 буюу 3.4 хувь нь санал, 4599 буюу 93.9 хувь нь өргөдөл, 132 буюу 2.7 хувь нь гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл,
гомдол



Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 696 буюу 14.2 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 175 буюу 3.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 709 буюу 14.4 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1073 буюу 21.9 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 211 буюу 4.3 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 2056 буюу 41.9 хувь нь бусад өргөдөл гомдол байна.



Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 4770 буюу 97.4 хувийг шийдвэрлэж, 127 буюу 2.6 хувь нь ажиллагаанд байна.




Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар

2016 оны эхний 6 сард Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 410 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 86 нэгж буюу 17.3 хувиар буурчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 1 буюу 0.6 хувь нь санал, 9 буюу 5.5 хувь нь гомдол, 155 буюу 93.9 хувь нь өргөдөл байна.





Иргэд, байгууллагаас цагдаагийн ерөнхий газрын удирдлагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 36 буюу 8.8 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 37 буюу 9.0 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 49 буюу 12.0 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 14 буюу 3.4 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 36 буюу 8.8 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 238 буюу 58 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



Гурав. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар

2016 оны эхний хагас жилд иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 398 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 150 буюу 37.7 хувь нь санал хүсэлт, 164 буюу 41.2 хувь нь гомдол, 64 буюу 16.1 хувь нь талархал, 19 буюу 4.8 хувь нь шүүмжлэл, 1 буюу 0.2 хувь нь өргөдөл байна.




Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 349 буюу 87.7 хувийг шийдвэрлэж, 49 буюу 12.3 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 104 буюу 26.1 хувийг 5 хоногийн дотор, 294 буюу 73.9 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2016 оны эхний хагас жилд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 797 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 113 нэгж буюу 12.4 хувиар буурч, 902 алба хаагч холбогдсоны 745 буюу 82.6 хувь нь офицер, 148 буюу 16.4 хувь нь ахлагч, 9 буюу 1.0 хувь нь энгийн ажилтан байна. Нийт өргөдөл гомдлын 729 буюу 91.5 хувийг барагдуулж, 68 буюу 8.5 хувь нь ажиллагаанд байна.



Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 33 буюу 4.1 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 66 буюу 8.3 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 4 буюу 0.5 хувь нь хэргийн хугацаа хэтэрсэн, 46 буюу 5.8 хувь нь бусдыг чирэгдүүлж танил тал харсан,

5 буюу 0.6 хувь нь хээль хахууль, шан харамж авсан, 198 буюу 24.8 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 40 буюу 5 хувь нь бусдыг зодож эрх чөлөөнд нь халдсан, 99 буюу 12.4 хувь нь ажлын хариуцлага алдсан, 13 буюу 1.6 хувь нь архидан согтуурсан, 4 буюу 0.5 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 289 буюу 36.3 хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль дүрэм зөрчсөн, зөрчлүүд эзэлж байна.

Зөрчлийн төрөл



Сахилгын арга хэмжээ авагдсан байдлыг авч үзвэл: Эрүүгийн хэрэг үүсгэхээр шилжүүлсэн 26, албанаас халсан 13, цол бууруулсан 2, цалин бууруулсан 142, сануулсан 51, алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдоогүй 489, нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан 14 байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТЭС